

**АРХАНГАЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН  
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
/Жилийн эцсийн байдлаар/**

2025.03.07

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	БИЕЛЭЛТ
1	ОУИТБС-ын дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Дэд зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгууллаа. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгыг дэмжих ажлын хүрээнд дэд зөвлөлийн албан хаагчид олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын ажлын албанаас болон Ашигт малтмал, газрын тосны газраас зохион байгуулсан 1 удаагийн сургалтад хамрагдлаа.
2	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБС-ын ажлын албанд хугацаанд нь хүргүүлэх	БМНС ХХК газрын төлбөр-271,936,255, ус ашигласны төлбөр-65,000,000, хог хаягдлын төлбөр-2,500,000 төгрөг, Армико майнинг корпорац газрын төлбөр-108, 664,904, ус ашигласны төлбөр -76,858,934, хог хаягдлын төлбөр-2,500,000 төгрөг, Алтай голд ХХК ус ашигласны төлбөр-3,076,320, хог хаягдлын төлбөр-2,500,000, Ашид бэхи ХХК ус ашигласны төлбөр-7,332,244 төгрөг, гарын төлбөр-1,447,052, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар-61,282,469 төгрөг, хог хаягдлын хураамж-2,220,000, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр-14,817,756, Бодь-Ар ХХК түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр-3,404,000 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.
3	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг олон нийтэд мэдээлэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах	2024 онд БМНС ХХК, Армико майнинг корпорац ХХК нь Цэнхэр сумын Засаг даргатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажилласан байна. БМНС ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 533,650 сая төгрөг, Армико майнинг корпорац ХХК 338,302 сая төгрөг, Алтайголд ХХК 32,200 сая төгрөг, Ашид бэхи ХХК 123,905 сая төгрөгний ажлуудыг хийсэн байна.
4	Байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн талаарх авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ, тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргах	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангаж ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явууллаа.Тухайн онд БМНС ХХК-аар 10 га талбайд техникийн, 5 га талбайд 5000 ширхэг үхрийн нүд, 3000 ширхэг хайлаас, 450 ширхэг улиасаар, 4 га талбайд олон наст ургамлаар

		<p>нийт 9 га талбайд биологийн нөхөн сэргээлт, Армико майнинг ХХК-аар 3 га талбайд техникийн нөхөн сэргээлт, Алтайголд ХХК-аар 1.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Бодь-Ар ХХК-аар Булган сумын Баянбулаг багт эвдэрч эзэнгүй орхигдсон 1 га, Ашид бэхи ХХК-аар эвдэрч эзэнгүй орхигдон, хогийн цэг үүссэн 2 талбайд техникийн нөхөн сэргээлтийг нийт 19 га талбайд техникийн, 9 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгүүллээ.</p>
--	--	---

---ooOoo---